

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025.12.08

Орхон

№	Зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Ин хэмжээ /сая.төг/ эх	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн явц
						2025 он	
<b>НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
<b>1.1. ЭРҮҮЛ МЭНД</b>							
1	1.1.1 Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгож, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. /Алсын хараа 2050-2.2.8; ЗГҮАХ-2.3.1; АХҮАЧ-2.1.8; АЗДҮАХ-2.5.1.1/	1	Иргэдийн эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ бүхий “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх. СӨБ-ийн хүүхдүүдийг витамин Д-гийн дархлаажуулалтанд хамруулна.	3.0	2020-2024 онуудад спорт тэмцээн, явган алхалт, нийтийн бүжиг, "Энэ жилдээ-Эрүүл жиндээ аян"-ыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 4360 иргэнийг хамруулсан байна.	Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, холбогдох байгууллагуудтай хамтарч, спортын өдөрлөг болон дасгал хөдөлгөөн, алхалтын өдөрлөгүүдийг зохион байгуулна. Нийт 350 иргэнийг хамруулна. СӨБ-ийн хүүхдүүдийг Д витаминжуулалтад хамруулна.	Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр “Алхалт -10000” аян зохион байгуулж өглөөний алхалтад 157, “Архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, хор хөнөөлийг таниулах” аян зохион байгуулж, тус аяны хүрээнд сургалт, гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж 124, төрийн албан хаагчийн “Эрүүл идэвхитэй амьдрал” арга хэмжээгээр 5 төрлийн тэмцээн зохион байгуулж 110 албан хаагч хамрууллаа. СӨБ-ийн 2-3 насны 95 хүүхдийг “Д” витаминжуулалтад хамруулсан.
		2	Хавдраас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	3.0	2024 онд хавдрын өвчлөлийн тохиолдол 21 байгаа бөгөөд өнгөрсөн оноосоо 22%-иар өссөн байна.	Явуулын амбулаторийн үзлэгийг жилд 1 удаа зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг зохион байгуулах. Тамхины хэрэглээний хор уршгийн талаар цахим орчинд болон ЕБС-ийн сурагчдын дунд контент бүтээх уралдаан зохион байгуулах.	ЭМТ-ийн амбулаторийн ЭХО оношлогоо үзлэгт 154 иргэн хамрагдсанаас элэгний өөрчлөлттэй хавдар болзошгүй 7 иргэнийг дээд шатлал руу явуулснаас 4 иргэнд элэгний хавдар батлагдаж хяналтад авсан. Энхтал багийн алслагдсан өрхийн иргэдэд явуулын амбулаторийн урьчдиглан сэргийлэх 4 удаагийн 8 чиглэлийн үзлэгт 173 иргэн хамрууллаа. Зорилтот насны 1122 иргэнд В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулахад В вирусын халдвартай-3, С вирусын халдвартай 8 иргэн илэрч, лавлагаа шатлалд илгээсэн. “Электрон болон янжуур тамхины хор уршиг”–ын талаар ЕБС-ийн ахлах ангийн 3 бүлгийн 84 сурагчид 3 удаа сургалт хийж, 158 гарын авлага тараалаа. Сумын ЭМТ-ийн цахим хаягаар тамхины хэрэглээний хор уршгийн талаар 3 удаагийн сэрэмжлүүлэг, зөвлөмж байршуулж 128 иргэн хандаж мэдээлэл авсан.
							Хэрэгжилт 100 хувь
							Хэрэгжилт 100%

2	1.1.2 Эрүүл мэндийн төвүүдийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, шинэ технологи нэвтрүүлж нутагшуулна. /Алсын хараа 2050-2.2.28; ЗГҮАХ-2.3.2; АХҮАЧ-2.1.1.7; ЗДҮАХ-2.5.2.1/	3	Хүүхдийн “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд СӨБ болон ЕБС-ийн сурагчдад шүдний эмчийн үзлэг тогтмол зохион байгуулна.	-	2024 онд нийт хүүхдүүдийн шүдний өвчлөлийн 34.9%-г нь эрүүлжүүлсэн байна.	Нүүр ам судлалын их эмчийн орон тоог зарлана.	Аймгийн “Батсурвалж” ХХК шүдний эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан эрүүл мэндийн даатгалаар 47 иргэний шүдийг эмчиллээ. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулагдсан 6 настны амны хөндийн үзлэгт 37 хүүхдэд үзлэг хийж, урьдчилсан сэргийлэх шүдний түрхлэг түрхэж, 18 хүртэлх насны 122 хүүхдийг шүдний үзлэг, эмчилгээнд хамрууллаа. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн шүдний эмчтэй ажлын 5 хоногийн 2 өдөр ажиллах гэрээ байгуулан шүдний ломбо тавих 104, шүд авах 65, сувгийн эмчилгээ 99, эм түрхэх эмчилгээг 21 нийт 294 иргэнд эмчилгээ хийлээ. Сумын ЭМТ-д ажиллах нүүр ам судлалын их эмчийн орон тоог нийтэд 3 удаа зарласан, эмч ирээгүй тул аймгийн хэмжээнд ажиллаж байгаа 4 эмчид суманд ажиллуулах талаар санал тавьсан. Хэрэгжилт 100%
		4	Уламжлалт анагаах ухааныг хослуулан уламжлалын эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, уламжлалтын эмчийн ажиллах нөхцөлөөр хангах	10.0	Одоо сэргээн засахын кабинетэд 1 их эмч ажиллаж байна. Ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж УБЧ шарлага-1, Бумба-100 ширхэг, иксра-1, хэт ягаан туяаны аппарат-1, Цахилгаан төөнүүр-1, Лазер-1, Улаан гэрэл-1 массажны сандал-1, татлагын ор-1 тус тус байна.	Сэргээн засахын тоног төхөөрөмжийг 1-2 төрлөөр нэмэгдүүлж нийт-150 иргэнд тусламж үйлчилгээг үзүүлнэ.	Тайлант хугацаанд уламжлалт анагаах ухааны их эмч 1 орон тоогоор ажиллаж, уламжлалт нөхөн сэргээх эмчилгээний тоног төхөөрөмжөөр 8 төрлийн эмчилгээг 176 иргэнд үзүүллээ. Хэрэгжилт 100%
		5	Энхтал багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх багийн эмчийн ажиллах нөхцөлөөр хангах	5.0	Энхтал багийн байранд багийн эмчийн 1 өрөө, шкап-1, ширээ-1, сандал-1, кушитик-1 өвчтөний хаалт-1, тарианы ширээ-1 тус тус байна	Энхтал багт багийн эмчийг багийн байран дээр тогтмол ажиллуулах. Улиралд 1 удаа явуулын амбулаториор үзлэг оношилгоо хийх, хүүхдийн товлолын дархлаажуулалтыг сар бүр хийнэ.	Энхтал багийн төвд багийн бага эмч томилон ажиллуулж 5 төрлийн эмнэлэгийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 842 иргэнд үзүүллээ. Энхтал багийн 173 иргэнийг 4 удаагийн явуулын амбулаторийн үзлэгт хамруулж, архаг хууч өвчтэй 55 иргэнийг багийн эмчийн хяналтад байлгаж, гэрийн эргэлт 12 удаа үзүүллээ. Тайлант онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр товлолын 6 төрлийн дархлаажуулалтад нийт 258 хүүхэд хамрагдсанаас Энхтал багийн 106 хүүхэд хамрагдсан. Товлолын дархлаажуулалт сумын хэмжээнд 100% хийгдсэн. Хэрэгжилт 100 хувь

		6	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургана.	0.5	2024 онд нийт эмч эмнэлгийн мэргэжилтнүүд 21 удаагийн сургалтад хамрагдаж нийт 45 кр багц цагийн сургалтад хамрагдсан байна.	Яаралтай тусламжийн сувилагчийг бэлтгэнэ. Нийт 50 кредит багц цагийн сургалтад хамруулна	Яаралтай тусламжийн мэргэшүүлэх 14 кредит багц цагийн сургалтад 1 сувилагч, хүүхдийн сувилагчийн мэргэшүүлэх сургалтад 1 сувилагч хамрагдаж тус тус төгссөн. ЭМТ-ийн 5 их эмч, 13 эмнэлгийн мэргэжилтнүүд 63 кредит цагийн сургалтад хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн. Хонгор сумын ЭМТ-д 4 сувилагчийг туршлага судлууллаа. Хэрэгжилт 100 хувь
3	1.1.3 Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Алсын хараа 2050-2.2.27; ЗГҮАХ-2.3.3; АХҮАЧ-2.1.4; ЗДҮАХ-2.5.3.1/	7	Биохимийн хагас анализатор аппаратаар хангах;	5.0	Стандарт MNS 5081:2013-т заасны дагуу багаж ариутгалын өрөөг тусд нь тохижуулж автоклав 2, хатаах шүүгээ 1, пакетлагч 1 бусад тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглон, лабораторид ийлдэс судлалын шинжилгээ болон бусад шинжилгээнүүд хийдэг болсон.	Биохимийн хагас анализатор аппаратаар авах	Сумын ЭМТ-ийн төв биохимийн хагас анализатор 2 аппараттай болсон бөгөөд аппарат ажиллуулах чадавхижуулах 3 хоногийн сургалтад лаборант Болорыг хамруулсан. Хэрэгжилт 100%
		8	Эрүүл мэндийн төвийн гадна пассатыг шинэчилж, дээврийг солих	300.0	2008 онд дээврийн их засвар хийгдсэн түүнээс хойш засвар хийгдээгүй.	Сумын ЭМТ-ийн гадна пассатыг хийж дулаан алдагдалтайг бууруулах, дээврийн засвар хийнэ.	Сумын ЭМТ-ийн гадна пассат, дээврийн засвар хийх ажлыг тендэрт шалгарсан “Онцот баян хайрхан” ХХК 287.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Хэрэгжилт 100%
		9	Хэвтэн эмчлүүлэх тасгийн эмчлүүлэгчдийн ая тухыг нэмэгдүүлэх зорилгоор цэвэр бохир усны шугамыг шинэчлэх, өдрийн эмчилгээний өрөөг тохижуулах, эмч эмнэлгийн ажилчдын угаалгын өрөөний тоног төхөөрөмжийг шинэчлэх	5.0	2005 онд их засвар хийгдсэн түүнээс хойш засвар хийгдээгүй. Өдрийн эмчилгээний өрөөнд дуслын хөлтэй сандал-1, дуслын хөл-2 байна.	Өдрийн эмчилгээний өрөөг тохижуулж, эмчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангана.	Өдрийн эмчилгээний өрөөг ЭМТ-ийн хүлээн авах хэсэгт байрлуулан 1 удаад 6 хүнд үйлчлэх хүчин чадалтайгаар зохион байгуулж байгууллагын төсвөөс 0.7 сая төгрөг зарцуулаа. Өдрийн эмчилгээгээр 1 өдөрт 20 хүнд эмчилгээ үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтайгаар ажиллаж 178 хүнд үйлчиллээ. Сумын Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 1.5 сая төгрөгөөр санхүүжүүлэн 6 хүний сандал худалдан авах шийдвэр гаргалаа. Хэрэгжилт 100 %

		10	Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, үр дүнтэй тасралтгүй зохион байгуулж үргэлжлүүлнэ.	1.0	2024 онд Элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт орвол зохих 916 иргэдээс 95% буюу 870 иргэнийг үзлэгт хамруулсан. Хөдөөгийн багийн нийт 649 хүн амын 70% буюу 454 иргэнийг мобайл технологиор урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	Элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт орвол зохих 100% хамруулах	Тус суманд 2025 онд байнга оршин сууж амьдарч байгаа иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт 100 хувь хамруулсан. Артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 2171 - 1734 иргэн хамрагдаж 79.8, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 1187- 1122 иргэн хамрагдаж 94.5, элэгний эрт илрүүлэг 1187-1122 иргэн хамрагдаж 94.5, умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг 210-132 иргэн хамрагдаж 62.8, хөхний өмөнгийн эрт илрүүлэгт 794-785 иргэн хамрагдаж 98.5, монгпен төслийн үзлэгт 1187-1734 иргэн хамрагдаж 79.8 хувьтай байна. Хэрэгжилт 100 %
		11	Эмчилгээний хоолны гал тогооны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	5.0	Эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй байна.	Эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмжийг 2-3 төрлийг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн төвийн гал тогооны тоног төхөөрөмжийг 2 төрлөөр нэмэгдүүлж богино долгионы зуух, аяга таваг ариутгагчаар нэмэгдүүлж 170.0 мянган төгрөгийг зарцууллаа. Хэрэгжилт 100%
		12	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ил тод, хариуцлагатай байлгаж, шуурхай хүргэх зорилгоор өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, эрүүл мэндийн төвийн цахим шилжилтийг эрчимжүүлж цахим эмнэлэг төслийг хэрэгжүүлнэ.	2.0	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ POS.WINGS цахим программаар тусламж үйлчилгээ явуулж байгаа. Иргэдэд мэдээ мэдээлэл түгээх хүргэх Фэйсбүүк цахим хаягтай. Цахим хаягаар нийт-219 төрлийн мэдээллийг иргэдэд хүргэсэн байна.	Цахим хаягийг хөгжүүлэх	Цахим эмнэлэг төслийн хүрээнд POSWINGS програмаар жор бичих, өдрийн болон дотрын эмчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламж, даатгалаар үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээ цахимжсан. Мөн Ehealth.gov.mn ээр цахим асаргаа, гүйцэтгэлийн төлөвлөгөө, бүртгэлүүд хөтлөгдөж, нягтлан бодох бүртгэлийг shilen.gov.mn, <a href="http://www.finance.gov.mn">www.finance</a> програмаар гүйлгээ хийгдэж хянагдаж, баталгаажиж, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Сумын ЭМТ-ийн “Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төв” цахим хуудас E-MONGOLIA-Д нэгдлээ. Төрийн албаны зөвлөлийн цахим систем hrm.csc.gov.mn-д хүний нөөцийн, hr.hdc.gov.mn эмчлэх сувилах эрхийн мэдээлэл, сургалтад хамрагдах зэрэг мэргэжлийн бүртгэлүүд цахим программаар хөтлөгдөж байна. “Орхон эрүүл мэндийн төв” ийн фэйсбүүк хаягаас нийт 270 гаруй төрлийн мэдээлэл, сурталчилгаа байршуулснаас 37.0 орчим иргэн хандсан. Хэрэгжилт 100%

		13	Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн 2 авто машины грашийг төвийн төвлөрсөн дулааны шугамд холбох	-	Одоогоор төвлөрсөн дулааны шугамд холбогдоогүй, цахилгаан халаагуураар халааж байна.	Дулааны шугамд холбох зураг төслийг хийлгэнэ.	Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн 2 авто машины грашийг төвийн төвлөрсөн дулааны шугамд холбоход шаардагдах 16.0 сая төгрөгийн төсвийг Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын инженерээр хийлгэсэн. 2025-2026 оны өвөлжилтийн үед автогражийн дулааныг хананд байлруулсан цахилгаан халаагч 1, үлээгч 1 хаалаагуураар шийдвэрлэлээ.  Хэрэгжилт 100%
<b>1.2 Боловсрол</b>							
4	1.2.1 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн орчныг сайжруулах, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах төсөл хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. /Алсын хараа-2050 2.1.3, АХҮЧ-2.1.2, 2.1.3, ЗДҮАХ-2.2.8, Боловсрол 2032 хөтөлбөр/	14	"Хүүхэд багачуудын суралцах орчинг сайжруулж 480 хүүхдийн шинэ сургууль барина."	5 200.0	Хуучин сургууль нь 1992 он ашиглалтад орсон дулаан алдагдал ихтэй маш хүйтэн өвөл хичээллэх боломжгүй болсон тул шинэ сургуультай болох шийдвэр гарсан	Шинэ сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11.2 тэрбум төгрөгийн 480 хүүхдийн шинэ сургуулийн барилгын ажлыг "Тэнгэрийн тэмдэг" ХХК гүйцэтгэж, гүйцэтгэл 70 хувьтай байна.  Хэрэгжилт 100%
		15	Хуучин сургуулийн барилгыг иж бүрэн засварлаж дотуур байр, төрийн албан хаагчдын байраар дахин ашиглах	-	Газар хөдлөлтийн улмаас барилгад цууралт үүссэн тул засвар хийх шаардлагатай	-	Одоо ашиглагдаж байгаа сургуулийн барилгын хэвийн үйл ажиллагааг хангаж сургууль, дотуур байрны барилгад 10.6 сая төгрөгийн урсгал засвар хийлээ.  Хэрэгжилт 100%
		16	9-р цэцэрлэгийн гадна пасат болон тохижилтын ажил хийх	12.0	Үндсэн барилга 140 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай. Анх 1976 онд анх ашиглалтад орсноос хойш их засвар болон барилгын пасатын ажил хийгдэж байгаагүй.	Цэцэрлэгийн гадна пасатын зураг төсөв хийлгэх	Бурхантын орд ХХК-аар цэцэрлэгийн гадна фасадыг 268.0 сая төгрөгөөр шинэчлэх ажлын зураг төсөв хийлгэсэн. Мөн батлагдсан төсвөөс 30.0 сая төгрөгөөр салбар бүлгийн хашаа шинэчлэн засварлаж, түлээ нүүрс хадгалах болон эд хөрөнгө агуулахыг сунгаж дээвэрлэсэн. Төв цэцэрлэгийн хашаанд 9:18 хэмжээтэй талбай цементэлж, тоглоомын талбай байгуулсан.
		17	"Багш хөгжлийн иж бүрэн цахим танхим болох /Ухаалаг дэлгэц, самбар, ширээ, компьютер, сандал, хэвлэгч, скайнер./ /ЗГҮАХ 2.2.4, АЗДҮАХ 2.4.3.1/"	5.0	Багш хөгжлийн танхим хүрэлцээгүй	Багш хөгжлийн танхимд засвар үйлчилгээ хийх	Сумын ОНХС-аас 20.0 сая төгрөгөөр ЕБС-ийн 5 ангид ухаалаг дэлгэц, гүйдэг самбар худалдан авч тоног төхөөрмжийг нэмэгдүүлсэн. Багш хөгжлийн танхимд 15.5 сая төгрөгөөр ширээ 2, ухаалаг дэлгэц 1, зөөврийн компьютер 4, принтер 1 нийт 8 тоног төхөөрөмж нэмэгдүүлсэн. Аймгийн "Шилдэг сургууль"-иар шалгарсан амжилтыг үнэлж аймгийн Засаг даргаас хаш чулуун ор, массажны сандал олгосныг багш хөгжлийн төвд байрлуулсан.  Хэрэгжилт 100%

		18	Цэцэрлэг, сургуулийн суралцагчдад "Өдөр бүр- Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлэх /ЗГҮАХ 2.1.2.13, АЗДҮАХ 2.4.1.5/	98.28	Нийт 180 хүүхдэд "Өдөр бүр - Сүү" хөтөлбөрийг өгч эхлүүлсэн	"Өдөр бүр - Сүү" хөтөлбөрт СӨБ, ЕБС-ийн 380 хүүхдийг хамруулна.	Өдөр бүр сүү хөтөлбөр хэрэгжүүлж 9 дүгээр цэцэрлэгийн 165 хүүхдэд 3.3 сая төгрөг, сургуулийн 6-12 дугаар ангийн 197 сурагчдад 3.2 сая төгрөгийн, нийт 362 хүүхдэд 6.5 сая төгрөгийн 1318.5 литр сүү өгсөн.
5	1.2.2 Хичээлээс гадуурх секц, дугуйлангуудыг бодлогоор дэмжих, хүүхдийг өөрийн авьяаст нь тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургах бодлого баримтална. 2.2.9 АЗДҮАХ	19	Сум орон нутгийн онцлогийг харуулсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх сурагчдыг хөдөлмөрт сургах зөв дадалтай хүүхэд бүтээх, бусад ЕБС-ийн хүүхдүүдийг сургуулийнхаа хүүхдүүдтэй танилцуулах харилцан зөв дадалд хэвшүүлэх зорилготой Орхон жимс ногоо "Хөдөлмөр" зуслангийн ажлыг эхлүүлэх	-	ХАА чиглэл хөгжсөн сумын хувьд Хөдөлмөр зуслан байгуулах бүрэн боломжтой	Сум орон нутгийн онцлогийг харуулсан хөдөлмөр зуслан байгуулах судалгаа хийх	Хөдөлмөр зуслан байгуулж хүүхэд байрлуулах байрыг эхний ээлжинд сургуулийн дотуур байрыг сонгохоор шийдвэрлэсэн. Материаллаг бааз, суурь бий болгох зорилгоор батлагдсан төсвөөс 1.3 сая төгрөгөөр гадна тоглоомын талбай байгуулж, сумын хүүхэд хамгааллын зардлаас 6.9 сая төгрөгөөр 40 хүүхдийн цагаан хэрэглэл, хөнжил, орны бүтээлэг шинэчилсэн. Аймгийн Засаг даргаас 30.0 орчим сая төгрөгийн үнэ бүхий гал тогооны тоног төхөрөөмжийг иж бүрэн шинэчилсэн.  Хэрэгжилт 100%
		20	Олон улсын эко цэцэрлэг хөтөлбөр хэрэгжүүлэх	2.0	Олон улсын эко цэцэрлэг, сургууль хөтөлбөрийн анхан шатны хөтөлбөрт хамрагдаж хүрэл гэрэгэ болзлыг хангасан.	Олон улсын эко цэцэрлэг, сургууль хөтөлбөрийн 2 дахь шатны сургалтад хамрагдаж "Мөнгөн гэрэгэ"-ний болзлыг ханган Жишиг Эко цэцэрлэг болсон байна.	Олон улсын эко цэцэрлэг, сургууль хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 2 дахь шатны сургалтад 5 багш хамрагдаж "Мөнгөн гэрэгэ"-ний шалгаруулалтад оролцох хүсэлтээ "Байгаль орчны мэдээлэл сургалтын төв"-д тайланг хугацаанд нь хүргүүлсэн. Хүрээнд цэцэрлэгийн ногоон аяны "Тэрбум мод" байгууламжийг нэмэгдүүлэн 5 төрлийн жимсний мод, 4 төрлийн чимэглэлийн мод, 2 төрлийн эмийн ургамлын мод нийт 113 ширхэг модтариллаа.  Хэрэгжилт 100%
		21	Хичээл сургалтын үйл ажиллагаанаас гадуур урлаг, спортын секц дугуйлан хичээллүүлэх	1.0	ЕБС, СӨБ нь урлаг, спортын нийт 20 төрлийн секц дугуйланд 192 хүүхдийг хамруулж байна.	ЕБС, СӨБ нийт 24 төрлийн секц дугуйланд 230 хүүхдийг хамруулна.	ЕБСургууль урлаг, спортын 17 төрлийн секц дугуйланд 354, СӨБ 9 төрлийн дугуйланд 9 бүлгийн 168 хүүхдийг хамруулж байна. ЕБС-ийн хөнгөн атлетикийн дугуйлангийн сурагчдаас 1 хүүхэд уртын харайлтын төрөлд хошой алтан медаль, буухиа төрөлд алт, хүрэл медаль, аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс 7 алтан медаль, 4 мөнгө, 3 хүрэл медаль авсан амжилт үзүүллээ. Крекитийн төрөлд 1 хүүхэд улсын аваргын алт, боксын төрөлд 1 хүүхэд улсын аваргын мөнгөн медаль, аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд охидын баг мөнгө, хөвгүүдийн баг хүрэл медаль хүртсэн амжилт

						гаргалаа. нэг хүүхэд мөнгө, хүрэл медал хүртсэн амжилт гаргалаа. Хэрэгжилт 100%	
		22	Солонгос улсын I M BREAK нэмэлт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	6.0	Хөтөлбөрийн дагуу I M BREAK сургалтын өрөөтэй 36 хүүхэд тоглох тоглоомтой болсон. Дархан-Уул аймгийн хэмжээнд туршлагаа түгээн дэлгэрүүлж 71 багшийг мэргэшүүлэх сургалтад хамруулж сертификатуулсан. 9 бүлгийн 180 хүүхдэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	"Солонгос улсад мэргэшүүлэх сургалтад багшийг хамруулна." 3	" бүтээлчээр хөгжүүлэе Бн гдуйрамдах Солонгос улсын M BREAK" нэмэлт хөтөлбөрийн мэргэшүүлэх сертификаттай .сургалтад 3 багш 1 албан хаагч хамрагдлаа Сөүл хотын Гуанаг дүүргийн "Гүриб хэнүн" цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан, туршлага солилцлоо. Хэрэгжилт 100%
6	1.2.3 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана. "Багшийн хөгжил" хөтөлбөрийг шинээр, "Чадварлаг багш" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. 2.1.3 АЗДҮАХ	23	Сайн багш хөтөлбөр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	3.0	Багш нарын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжүүлэх ба 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.	"Хүний багш" сэдэвт илтгэлийн уралдааныг 1,2,3-н үе шаттай зохион байгуулна.	"Хүний багш" сэдэвт илтгэлийн уралдааныг 1, 2,3 үе шаттай зохион байгуулж аймгийн 16 ЕБС, 11 СӨБ-д албан бичгээр хүргүүлж, 25 илтгэл ирсэнээс 2-р шатад 18 илтгэлийг сонгон шалгаруулж, 1-р шатанд 10 шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан 4 багшийг шалгаруулж сумын Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 3.0 сая төгрөг зарцуулах шийдвэр гаргалаа. Хэрэгжилт 100%
		24	"Мөрөөдөлтэй Монгол хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	5.0	Орхон сумын хүүхдүүдийг зорилготой, мөрөөдөл тэмүүлэлтэйгээр хичээл сургалтын үйл ажиллагаандаа орох чанартай боловсрол эзэмшүүлэх хэрэгцээ үүссэн.	Мөрөөдөлтэй Монгол хүүхэд хөтөлбөрийн хүрээнд хүүхэд хөгжлийн Интерпрэнц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хөтөлбөр маань 4 жилийн хугацаанд хэрэгжиж хэвшүүлэх үйл ажиллагааг эхлүүлж 5 багш, 30 хүүхдийг хамруулна.	Мөрөөдөлтэй Монгол хүүхэд хөтөлбөрийн хүрээнд "Мөрөөдлийн талаар" цуврал лекц зохион байгуулж 1-12 дугаар ангийн 409 хүүхэд хамрагдлаа. Багш бүр ажилдаа ирэхдээ хүүхдүүдийнхээ мөрөөдлийг бүтээх гэж ирдэг дадалд суралцах ажлыг 1 удаа зохион байгуулж 3 хэсэгт хуваан 409 хүүхдийг хамрууллаа. Хүүхэд хөгжлийн Интерпрэнц хөтөлбөрт хамрагдах 30 хүүхэд, 5 багш сонгогдсон бөгөөд байгууллагын төсвөөс 1.8 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн. Хэрэгжилт 100%

		25	Сургуулийн номын санг шинэчилж, хими физик биологийн хичээлийн лаборатори танхим, орон нутгийн онцлогийг харуулсан туршилтын талбайг шинээр байгуулна	5.0	Хими биологийн кабинет байхгүй	Хими, биологийн кабинет байгуулж, эко клубийн үйл ажиллагааг эхлүүлнэ	Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөр Хими биологийн кабинетад “Монгол атлиус хай лэнд” ХХК-иас 8.0 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн авах шийдвэр гаргаж, гэрээ байгууллаа. ЕБС-ийн 20 сурагчтай эко клуб байгуулагдсан. Сумын Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 8.0 сая төгрөгийн үнэ бүхий химийн 29, биологийн 6 төрлийн тоног төхөөрөмж худалдан авах шийдвэр гаргасан. Хэрэгжилт 100%
		26	СӨБ-ын багш платформ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	1.9	Төслийн танилцуулга, төсөл илгээсэн	14 багшийг анхан шатны сургалтад хамрагдаж, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүнтэй болно.	СӨБ-ын “Багш платформ төсөл”-ийн 2 удаагийн сургалтад 18 багш, туслах багш нар хамрагдаж 2 сая төгрөгийн үнэ бүхий 1 багц ном, гарын авалга хэрэглэгдэхүүнээр хангасан. Хэрэгжилт 100%
		27	СӨБ-ын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд - STEAM шимт боловсрол төслийг хэрэгжүүлэх	15.0	STEAM байхгүй	Хүүхдийн бүтээлч сэтгэхүүнийг хөгжүүлэх STEAM тоглоомын төсөлд хамрагдах хүсэлт илгээх, тоглоомтой болох ажлын эхлүүлэх	Хүүхдийн бүтээлч сэтгэхүүнийг хөгжүүлэх STEAM тоглоомын төсөлд хамрагдах хүсэлт илгээн сая 3.6 “ төгрөгийн 2 багц 36 ширхэг блокl M BREAK” олон улсын хөтөлбөрSTEAMлого тоглоомтой боллоо Хэрэгжилт 100%
1.3 Хөдөлмөр нийгмийн хамгаалал							
	1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хамтын ажиллагааг дэмжинэ. Алсын хараа-2050 1.2.4, ЗГҮАХ-3.3.6.10, АЗДҮАХ- 2.2.1	28	Зорилтод бүлгийн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, орлогын эх үүсвэртэй болоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх	6.0	“Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөрийн хүрээнд нийгмийн халамж хүртэгч-Зорилтот өрх, хөдөлмөрийн насны 11 иргэнийг мэргэжил эзэмших сургалтад, ОНОТХҮ-ний хамт бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох буцаан төлөх нөхцөлгүй төсөл хөтөлбөрт 10 иргэнд 9.0 сая төгрөг, иргэн аж ахуй эрхлэгчийн санхүүгийн дэмжлэгт 8, малжуулах төсөлд 10 иргэн, нийт 11	Зорилтод бүлгийн 8 иргэнийг мэргэжил эзэмшүүлэх сургалтад, 3 иргэнийг орлогын эх үүсвэртэй болох санхүүгийн дэмжлэгт хамруулсан байна	“Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөрийн хүрээнд нийгмийн халамж хүртэгч-зорилтот өрх, хөдөлмөрийн насны ажилгүй, мэргэжилгүй иргэдийн судалгааг үндэслэж хөдөлмөрт бэлтгэх, суурь ур чадвар олгох, ажлын ярилцлагад бэлтгэх сертификаттай сургалтад 31, аж ахуй эрхлэх сургалтад 9 нийт 40 иргэнийг сургалтад хамруулж, орлогын эх үүсвэртэй болох санхүүгийн дэмжлэгт зорилтод 7 өрхийн 14 иргэн ажлын байраар хангаж орлогын эх үүсвэртэй болгох, өрхийн аж ахуй эрхлэх 54.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Хэрэгжилт 100%

					иргэнийг мэргэжил эзэмшүүлж		
7					28 иргэнг ажлын байраар хангаж орлогын эх үүсвэртэй болгох, өрхийн аж ахуй эрхлэх 61.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн		
		29	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ЕБС-ийн 9,12 дугаар ангийн сурагч, хөдөлмөрийн насны ажилгүй мэргэжилгүй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах	Тухайн жилд батлагдсан төсөв	Сургалтад хамрагдсанаар зорилгоо тодорхойлж, ажилд орох эсвэл мэргэжлээр суралцах эрмэлзэлтэй болно.	9, 12 дугаар ангийн сурагчид болон Хөдөлмөрийн насны 30 иргэн хамруулсан байна.	Хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын “Ажлын байран дах зөөлөн ур чадвар, цахим хэрэглээний мэдлэг олгох” сургалтанд хөдөлмөрийн насны 9 иргэн хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг “Эндээ хөгжил” НҮТББ-ын Мөндөө хөдөлмөрийн хувийн биржтэй хамтран 9-12 дугаар ангийн 34 сурагчид, хөдөлмөрийн насны 31 иргэнг хамрууллаа.  Хэрэгжилт 100%
8	"1.3.2 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд аж ахуй эрхлэхэд нь зориулж санхүүгийн дэмжлэг олгоно. /ЗГҮАХ-2.1.2.3/ /Алсын хараа-2050-ийн 2.3.1, ЗГҮАХ-2.1.2.3, АЗДҮАХ 2.2.1.2/"	30	Иргэн, ААНБ-д сангуудаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх	82.0	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 5 хувийн хөнгөлөлттэй зээлийг 31 иргэн, 3 ААНБ 1.2 тэрбум төгрөг авсан.	20 иргэн, ААНБ-д сангуудаас санхүүгийн дэмжлэг үзүүлнэ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэн, аж ахуй эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа”-ны хүрээнд: шинээр нөхөрлөл, хоршоо байгуулсан 3 иргэн 60.0 сая төгрөгийн зээл олголоо.  Хэрэгжилт 100%
		31	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, зорилтот бүлгийн иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, гэр бүлийн бичил бизнесийг дэмжих.	20.0	2024 онд ажлын байр болон хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй 79 иргэнг Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан "Е JOB"-д бүртгэж 68 иргэнийг орлогын эх үүсвэртэй болгох, өрхийн аж ахуй эрхлэх, ажлын байраар хангаж 299.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй 3, ахмад настан 5, иргэн 5, зориолтот өрхийн 3 нийт 16 иргэнд дэмжлэг үзүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэн, аж ахуй эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа”-ны хүрээнд: “Иргэн, аж ахуй эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа”-ны санхүүгийн эрхлэлтийг дэмжих 50 хувийг буцаан төлөх, 50 хувийг нь буцаан төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгийг 3 иргэнд 30.0 сая төгрөг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 7 ахмадад 64.0 сая төгрөг, малгүй болон цөөн тооны малтай өрхийг малжуулах төсөлд 7 өрхийн 14 иргэнд 56.0 сая төгрөгийн мал, шинээр нөхөрлөл, хоршоо байгуулсан 3 иргэнд 60.0 сая төгрөг, нийт 25 өрхийн 32 иргэнийг өрхийн аж ахуй, ажлын байраар хангаж 259.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээ.  Хэрэгжилт 100%

1.4. Соёл урлаг, спорт

9	"1.4.1. Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөрүүдийг дэмжиж нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх нөлөөллийн цогц ажлуудыг зохион байгуулна. /Алсын хараа-2050 1.2.4, ЗГҮАХ-3.3.6.10, ЗДҮАХ-3.5.1.2.6.2, АЗДҮАХ 3.5.1.2"	32	Музейн жишиг өрөөтэй болж, түүх дурсгалын биет, биет бус дурсгалт газруудын хадгалалт хамгаалалтыг сайжруулж сурталчлан ажиллана.	10.0	Музейн өргөтгөх өрөөг бэлдсэн.	Үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан шилэн хорготой болгох.	Музейн өрөөг өргөтгөх засварын ажилд 3.0 сая төгрөг зарцуулж, засварын ажил 80 хувьтай байна. Сумын нутаг дэвсгэрт байрлаж буй хөшөө дурсгал, булш хиргисүүр түүхэн дурсгалт үл хөдлөх өвийг сурталчилах, соёлын өвийг хадгалан хамгаалах, соёлын өвийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийн талаар иргэдэд эрх зүйн мэдлэг олгох зорилгоор видео хэлбэрээр танилцуулага хийж “Дархан-Уул Орхон сумын Соёлын төв” цахим хуудсанд байршуулж 18.3 мянган иргэн хандаж мэдээлэл авсан. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 1 иргэнийг бүртгэн, 4 арга хэмжээнд 15 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчиллаа. Хэрэгжилт 100%
		33	Номын сангийн үйлчилгээний чанар стандартыг сайжруулах ажлыг үе шаттай хийнэ.	3.5	Одоогийн байдлаар мэргэжлийн номын санч байхгүй.	Мэргэжлийн боловсон хүчинтэй болох, уншигчдын оюуны хэрэгцээг хангах ном хэвлэлийг нэмж худалдан авах.	Номын сангийн “10 ухаан” холбооны сургалтын төвийн “Чадамжийн гэрчилгээ”-тэй төгссөн номын санчтай боллоо. 29 боть номоор баяжилт хийж, 680.0 мянган төгрөгийг зарцууллаа. Сумын Засаг даргын хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэх зардлаас 500.0 төгрөгийн ном худалдан авч баяжилт хийх шийдвэр гаргалаа. Хэрэгжилт 100%
		34	Соёлын биет бус өвийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.	-	Одоогийн байдлаар мэргэжлийн багш байхгүй.	Биет өвөд бүртгэлтэй түүхэн дурсгалт газруудын нарийвчигсан тоог гаргах, хувийн хэрэг нээх. Бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах. Биет бус өвийг уламжлан тээгч иргэдийн судалгааг гаргаж цаашид хүүхэд залуучуудад түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Хэл хуур хөгжмийг сурталчлах тоглолт зохион байгуулж, 120 иргэн хамрагдлаа. Соёлын биет өвд бүртгэлтэй 5 газарт хувийн хэрэг нээж 2 удаа хяналт тавилаа. Аймгийн баяр наадмын хүрээнд “Дээлтэй монгол наадам”-ыг Дархан хотын соёл амралтын хүрээлэн, кино орон зайд зохион байгуулагдаж, 70 өв уламжлагч “Нүүдэлчин Монгол” дэлхийн фестивалд 6 өв уламжлагч тус тус оролцлоо. Хэрэгжилт 100%
		35	Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийг дэмжих	5.0	Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийг дэмжих төвлөрсөн өрөө байхгүй	Хүүхэд гэр бүл залуусын хөгжлийг дэмжих өрөөтэй болгож тоног төхөөрөмжийг	Соёлын төвд хүүхэд гэр бүл залуусын хөгжлийг дэмжих “Хүүхэд хамгаалах” өрөөг бий болгож тохижууллаа. Хэрэгжилт 100

						нэмэгдүүлэх.	
1 0	"1.4.2. Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, чөлөөт уран бүтээлчдийн шинэ бүтээл, төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, урын сан, музей, номын сангийн сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлнэ. /Алсын хараа-2050 1.1.19, ЗГҮАХ-3.3.6.10, ЗДҮАХ-3.5.1.3 ЗДҮАХ 3.5.1.2"	36	Соёлын үйл ажиллагааг идэвхжүүлж материаллаг баазыг нэмэгдүүлэн орчин үеийн чанар стандартын шаардлагад нийцсэн хөгжим техник хэрэгслийн шинэчлэх, урлаг зааланд засвар хийх	50.0	Одоогийн техник хэрэгсэл элэгдэж хоцрогдсон, шинэ тоног төхөөрөмж хангамж муу байна.	Тоног төхөөрөмжийг шинэчлэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Төвийн бүсийн соёлын байгууллагуудыг хэрэгцээт тоног төхөөрөмжүүдээр хангах" (СОЯ/20240102063) төслийн хүрээнд 4 морин хуур, хуур хөгжимт нэмэгдүүллээ. Соёлын төвийн урлаг заалыг чимэглэхэд 2.3 сая, өсгөгч, босоо яригч, процессор авч 4.0 сая төгрөгийг зарцууллаа. Сумын наадмын үйл ажиллагаанд зориулж галын Тулга авахад 3.0 сая төгрөг зарцууллаа. Хэрэгжилт 100%
		37	Соёлын төвийн гадна пассат ажил хийх.	10.0	Дээврээс дусаал гоожиж хананд цууралт өгч дулаан алдагдаж байгаа.	Мэргэжлийн байгууллагаар зураг төсөв хийлгэх	Соёлын төвийн гадна пассат хийх 97.8 сая төгрөгийн тендер зарлагдаж "Халхаан булаг" ХХК шалгарч, гүйцэтгэл 100 хувьтай байна. Хэрэгжилт 100%
1 1	1.4.3.Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг иргэдэд төлөвшүүлнэ. /Алсын хараа-2050-3.5, ЗГҮАХ-2.1.1.32, ЗДҮАХ- 2.6.1 X 3.5.1.2	38	"3x3 сагсан бөмбөгийн стандарт талбайг Баян Өлзийт болон Энхтал багуудын хорооллуудад барьж байгуулна."	25.0	3x3 сагсан бөмбөгийн стандарт хангасан талбай байхгүй	Төвийн хэсэг Төмөр замын 24-н айлын дэргэд стандартын 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулна.	"Анто-Од" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 21.1 сая төгрөгийн өртгөөр сагсан бөмбөгийн 3*3 талбай хийж, гүйцэтгэл 100 хувьтай байна. Хэрэгжилт 100%
		39	Иргэдийн амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх "Гэрэлт толгод", өвлийн спортыг хөгжүүлэх, хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх	20.0	Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх Орхон-50 цогцолборыг 2018 онд байгуулсан.	Хоккейн талбай, цана чарга зэрэг өвлийн спортоор хичээллэхэд мэргэжлийн багштай хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх	Сумын БӨБагийн суврагатай толгойн ард өвлийн спортын талбай байгуулах газрыг сонгож, зургийг мэргэжлийн байгууллагын архетикуртаар хийлгэхээр шийдвэрлэсэн. Хэрэгжилт 100%
		40	Сумын иргэд, хүүхэд залуусыг олон төрлийн секц дугуйлангаар суралцаж хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлж мэргэжлийн боловсон хүчнээр хангаж хөгжүүлнэ.	1.0	Дугуйлан секц явуулах орчин нөхцөл байгаа хэдий ч хүний нөөцийн хомсдолтой, санаачлаг дутмаг байна	Хөдөлгөөний дутагдлаас сэргийлсэн нийтийн биеийн тамир болон бүжгийн дугуйланг мэргэжлийн багшаар заалгуулж тогтмол хичээллүүлэх, үндэсний спортын секц дугуйланг орон нутагт хөгжүүлэх	Сумын Соёлын төвд такевондо, боксын дугуйлан хичээллэж 20 хүүхэд, гар бөмбөгийн дугуйланд 20 хүүхэд, сагсан бөмбөгийн дугуйланд 26 хүүхэд, сарапон сампингийн дугуйланд 20 хүүхэд, бүжгийн дугуйланд 35 хүүхэд, 20 иргэн нийт 5 дугуйланд 141 хүүхэд хамрагдаж байна. Хэрэгжилт 100%

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

12	"2.1 Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ. /Алсын хараа 2050-8.1/"	41	"Хөвд цөөрөм" төслийг хэрэгжүүлж үерийн далан байгуулах. (АЗДҮАХ-1.1.8.4)	-	Хөвд цөөрөм төслийн зураг төсөв боловсруулсан.	Хөвд цөөрөм үерийн далан байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	Шарын голын услалтын системийн толгойн барилга хэсэгт хөвд цөөрөм байгуулах зураг төсвийг ХХААХҮЯ-ын харьяа "Усалгаатай газар тариалан" төсөлд хамруулахаар сумын Засаг даргын 2025 оны 01 тоот албан бичгээр төслийн багт хүргүүлсэн. Төслийн багаас 79-ийн услалтын системийг сэргээн засварлахаар шийдвэрлэж, зураг төсвийн ажлыг "Хайдродизайн прожект" ХХК, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлэгээг "Грийннатур ланд" ХХК гүйцэтгэж байна. Хэрэгжилт 100%
		42	Тариалангийн талбайн цахилгаанжуулах ажлыг дуусгах	211.0	Шарын голын услалтын системийн 1, 2, 3-р сувгийг цахилгаан шугамыг татсан.	79-н тариалангийн талбайг цахилгаан шугам татах	Сумын Орон нутаг хөгжүүлэх сангийн 223.9 сая төгрөгийн хөрөнгөөр 79-ын услалтын системийн тариалангийн талбайд цахилгаан шугам татах тендер сонгон шалгаруулалтад "Цац эрчис" ХХК шалгарч, гүйцэтгэл 100 хувьтай байна. Хэрэгжилт 100%
		43	Энхтал багийн Бүрэнтолгой хэсгийн цахилгаан эрчим хүчний чадлыг нэмэгдүүлж, Бүрэнтолгой, 96-р зөрлөг хэсгийн гудамжны гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг хийх	276.0	Цахилгааны хүчин чадал бага, гэрэлтүүлэггүй	Бүрэнтолгой хэсгийн цахилгаан эрчим хүчний зураг төсөв хийлгэх, цахилгааны эрчим хүчийг нэмэгдүүлэх ажлыг хийх	2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Энхтал багийн Бүрэнтолгой хэсгийн цахилгаан эрчим хүчийг нэмэгдүүлэх ажлыг tender.gov.mn сайтаар 4 удаа, orkhon.da.gov.mn сайтаар 4 удаа, Орхон Тамгын газар фэйсбүүк хуудсаар 4 удаа зарлахад оролцогч оролцоогүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тендерийн үйл ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон. Энхтал багийн Бүрэнтолгой хэсгийн төв хэсэгт 2 камер шинээр суурилуулсан ажиллаж байна. Хэрэгжилт 100%
		44	Дулааны нэгдсэн төв барих. (АЗДҮАХ-1.1.8.7)	1.5	Сумын дулааны шугам сүлжээ бүгд тусдаа жижиг эх үүсвэрээс хангаж байна.	Мэргэжлийн байгууллагуудтай уулзаж судалгаа хийх	БНХАУ-ын Ханмөрөн мужийн аж ахуйн нэгжийн төлөөлөл Сэлэнгэ аймагт айлчлах арга хэмжээг зохион байгуулах үеэр манай сумын дулааны шугам сүлжээтэй танилцаж хамтран санал солилцож сумын Хот байгуулалтын хөгжлийн төлөвлөгөө батлагдаж гарсаны дараа уулзахаар шийдвэрлэлээ. . Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэстэй хамтран дулааны нэгдсэн төвтэй болгох судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр шийдвэрлэж, 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хот байгуулалтын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж мэргэжлийн байгууллагатай зөвшилцөн газрын байршлыг сонгосон. Хэрэгжилт 100%

		45	Сумын төвийн 11 км засмал замын их засварын ажлын зураг төсвийг хийж засварын ажлыг эхлүүлэх /ЗДҮАХ-1.1.5.1/	-	Орхон руу салдаг авто замд эвдрэл гэмтэл үүссэн байна.	-	Аймгийн Засаг даргын нөөц сангаас 7.0 сая төгрөгийн санхүүжүүлж Дархан Сэлэнгийн авто замаас сумын төв хүртэлх 11км замын эвдрэлтэй хэсэгт асфальтан нөхөөс хийсэн. Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ ато зам дагуу 8 тэмдэг тэмдэглэгээ байрлуулж 1.2 сая төгрөг зарцуулсан. Мөн замын зарим хэсгүүдэд үүссэн нүхнүүдийг 3 удаагийн давтамжтайгаар цементээр дүүргэж, зам дагуу үүссэн хог хаягдлыг 4 удаа цэвэрлэж, 11 нүхэн гарц дахь хог хаягдал, цас цэвэрлэж шар усны үерээс хамгаалсан. Их хэмжээний орсон цас, цасан шуурганы улмаас үүссэн хунгар, хаагдсан замыг 6 удаа ковшоор түрж, 15 тн давс, 3 тн бодис цацаж цэвэрлэлээ. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.2 сая, гамшгаас хамгаалах сангаас 12.0 сая төгрөг зарцууллаа. Хэрэгжилт 100%
		46	Энхтал багийн Бүрэнтолгой хэсгийн 7 км замыг Дархан-Хушаат чиглэлийн төв замтай хатуу хучилттай холбох /ЗДҮАХ-1.1.5.1/	56.0	Шороон замаар холбогдож байна.	Хатуу хучилттай замын зураг төсвийн ажлыг хийх	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар замын зураг төсвийг 56.0 сая төгрөгөөр "Мөнхийн тод зам" компани хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 100%
		47	Тосгон Шар дэрс хэсгийг холбосон төмөр гүүрийг төмөр бетон гүүр болгох	-	Гүүрний насжилт дууссан, үерт гүүрний үндсэн хийц идэгдсэн.	-	Шар дэрсний гүүрний төмөр хийцийн эвдрэлийг 1 удаа засаж өнгийг сэргээж будсан. Мөн голын урсгалаар эрэг нь идэгдсэн хэсэгт хучилтын хавтангаар хамгаалалт хийсэн. Шар дэрсний гүүрийг төмөр бетон болгох ажлын ажлын зураг төсвийг Мөнхийн тод зам ХХК-аар гүйцэтгүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх саналаа аймгийн Засаг даргаар уламжлан Сангийн яаманд хүргүүлсэн. Хэрэгжилт 100%
		48	Шарын голын услалтын систем доторх тариалангын талбайн зам, 79-н давааны зам засвар, Дэлгэр хорооллын өгсдөг шат шинээр хийх	20.0	Зам даваа эвдрэлтэй байгаа.	79-н давааны зам засварыг хийх	ОНХС-ийн 20.0 сая төгрөгөөр 79 давааны зам засварын ажлыг Тохижилт ОНӨААТҮГ гүйцэтгэсэн. Хэрэгжилт 100%
			Цэвэрлэх байгууламжийн хашааг шинээр барих, ойжуулах, усан сангийн хамгаалалтын	20.0	Усан сангийн хамгаалалтын хашааны ашиглалтын хугацаа дууссан. Камергүй.	Усан сангийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийх	Цэвэрлэх байгууламжийн хашаанд 60 ширхэг мод тарьж, 1.5 метр өндөртэй 219 метр хашаа, усан сан тойруулж 1.8 метр өндөртэй 240 метр төмөр хашаа барьж хамгаалалт хийж, 30.6 сая төгрөг зарцууллаа.

		49	хашааг шинэчлэн засварлаж, камержуулах				Мөн 385.0 мянган төгрөгийн үнэ бүхий 8 камер суурилууллаа. Цэвэр усан сан болон өргөх худагт мэргэжлийн байгууллагаар 1 удаа ариутгал халдваргүйтэл хийлгэж, усны шинжилгээ өгсөн. Хэрэгжилт 100%
		50	82 айлын хорооллын инженерийн шугамын ажлыг үргэлжлүүлэн хийх	10.0	24 айлын дэд бүтцийн ажил хийгдсэн.	10 айлын инженерийн шугамын ажлыг хийх	2025 онд батлагдсан төсөв, төсвийн хэмнэлтийн тухай хууль, бүсээ чангалая уриатай төсвийн хасах тодотголтой холбоотой хөрөнгийн эх үүсвэр хасагдсантай холбоотой 10 айлын инженерийн шугамын ажил үргэлжлүүлэн хийх боломжгүй болсон тул 2026 оны төлөвлөгөөнд шилжүүлэн тусгахаар шийдвэрлэлээ. Хэрэгжилт 30%
		51	Хорооллуудад ундны усны зориулалттай худаг барих	30.0	Хорооллуудад айл өрхүүд хөрсний хатуулаг ихтэй ус хэрэглэдэг.	Судалгаа, зураг төсөв хийх	Богичийн дэнжийн ундны усны зориулалттай худагт ухаалаг карттай болгож үйлчилгээний чанарыг сайжруулсан. Сумын ИТХ-ын дарга, сумын Засаг даргаас Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын худгийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалснаар Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын цэвэр усны төв шугамтай холбосон нийтийн цэвэр усны ухаалаг худаг байгуулахаар шийдвэрлэлээ. Хэрэгжилт 100%
		52	Энхтал багийн Хар морьтын хөтөл, Орхон салдаг хэсэгт цахилгаан эрчим хүч холбох	5.0	Цахилгааны байхгүй шугам	Зураг төсөв хийх	Баян-Өлзийт багийн Орхон салдаг хэсэгт цахилгааны эрчим хүчний эх үүсвэрийн зураг төслийг ДСЦТСтанцын мэргэжлийн хүнээр хийлгэж, хөрөнгийн эх үүсвэрийг тус компаниар шийдвэрлүүлэхээр санал солилцож урьдчилсан байдлаар ам тохиролцоонд хүрсэн. Хэрэгжилт 100%
		53	Эко жорлон төсөл хэрэгжүүлэх. /ЗДҮАХ-1.1.3.4/	50.0	Одоогоор 19 айл эко нойлтой байна	Сумын төвийн 25 өрхийг эко нойл хийнэ	Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-аас эко нойл болон хогийн савны судалгаа гаргаж айл өрхөд танилцуулж, Тосгон хорооллын 18 айл өрх, Шар дэрс хорооллын 16 айл өрхийг эко нойлтой болголоо. Засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас 4.0 сая төгрөгөөр ЗДТГ, баг, төмөр замын өртөөний хэсэгт 1 эко 00 хийх гэрээ байгууллаа. Хэрэгжилт 100%

13	"2.2 Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.. /Алсын хараа 2050-8.3.6/"	54	Тариалангийн талбайд "Ойн зурвас" байгуулах. /ЗДҮАХ-3.12.4/	420.0	Хөрсний шинжилгээгээр хөрсний үржил шим хүчтэй салхины нөлөөгөөр муудаж байна.	50 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах	Хүнсний ногоо тариалах зориулалттай 7 иргэн, 1 ААНБ-ын эзэмшлийн 57 га талбайд ойн зурвас байгуулах зураглал гаргаж сумын Засаг даргын 2025 оны 01-11 дугаарт албан бичгээр ХХААХҮЯамд хүргүүлсэн. Баян-Уулын тариалангийн 50 га талбайд 2024 онд ойн зурвас байгуулах чиглэлээр тендерт "Агрофорест" ХХК шалгарч ойн зурвасыг ажлыг тайлант онд дуусгаж 2 га талбайд нөхөн тарилт хийж, 2 удаа усалгаа, хөнөөлт шавьжийн гаралт ихэссэнтэй холбогдуулан 1 удаа шавьж устгалын ажил хийсэн. Мөн тариалангийн талбайг хамгаалах ХХААХҮЯамаас 565.9 га талбайг хаших 5200 ширхэг шонг нийлүүлсэн. Хэрэгжилт 100%
		55	Атар-4 аян хөтөлбөрийг дэмжих, орон нутагт эхлүүлэх /ЗДҮАХ-3.8.4/	20.0	Тариалангийн эргэлтийн талбайн хүрэлцээ хангамж муутай	Элэгдэл эвдрэлд орсон тариалангийн талбайн судалгааг гаргаж малын тэжээлийн ургамал тариалах, бордож талбайг эргэлтэд оруулах	2021, 2023 онд үерийн улмаас элэгдэлд, эвдрэлд орсон ашиглалтгүй байгаа 37 иргэний эзэмшлийн 98 га талбайн судалгааг гаргасан. Тайлант хугацаанд 2 иргэн 10 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 2 ААНБ, 18 иргэн 67 га талбайд хөрс боловсруулалт хийж малын бууцаар бордож 3 төрлийн таримал ургамал тариалсан 21.0 га талбайг өнжөөсөн. Хэрэгжилт 100%
		56	Хүнсний хувьсгал хөтөлбөр хэрэгжүүлэх. /ЗДҮАХ-3.8.4/	20.0	Монгол Улсын хүнсний ногооны 15-20%-ийг дангаараа хангаж байна.	Органик бордооны хэрэглээ чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулна.	Улсын тариаланчдын зөвлөгөөний салбар зөвлөгөөнд төмс, хүнсний ногооны хортон шавьжтай тэмцэх, хөрсний үржил шимийг хамгаалах, бордох, хүнсний ногооны үйлдвэрлэл өнөөгийн байдлын талаарх мэдээлэл, техник, тоног төхөөрөмж, бордооны үзэсгэлэн худалдаанд 57 тариаланч тус тус оролцсон. ХХААХҮЯамны харьяа Ургамал хамгааллын газраас 2025 оны хаврын тариалалттай холбогдуулан төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд ургамлын хөнөөлт организмтай тэмцэх, ургамал хамгааллын бүтээгдэхүүний хэрэглээний талаар зөвлөгөө өгөх талбайн сургалтад 7 тариаланч хамрагдсан. Хэрэгжилт 100%

		57	Хагас автомат зоорь барих. (АЗДҮАХ-1.1.8.7)	5.0	Уламжлалт нүхэн зоорин байгууламжаар шийдэж байна.	Улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрт хүнсний ногоо хадгалах механикжсан зоорь байгуулах чиглэлээр дээд шатны байгууллагад саналыг уламжлах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүнсний ногоо хадгалах зоорийн аж ахуйд хөргөлтийн систем суурилуулах боломжтой 4 зоорийн судалгаа, хөргөлтийн системийн техникийн тодорхойлолт гаргаж ХХААХҮЯамд хүргүүлсэн. Улсын төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн хадгалах 16.0 тонны багтаамжтай гүн хөлдөөгчтэй боллоо. Хэрэгжилт 100%
		58	Гурван улирлын хүлэмж байгуулах. (АЗДҮАХ-1.1.8.9)	50.0	Сумын хэмжээнд 82 иргэн 1.1 га талбайд зуны хүлэмжийн аж ахуйг эрхэлж байна.	1.5 га талбайд зуны хүлэмжийн аж ахуйг хүргэх	Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэх 6х10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмжийн захиалга авч одоогоор 5 иргэн, 1 ААНБ 10 хүлэмж хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр худалдан авсан. Сумын хэмжээнд тайлант онд 83 иргэн 2 ААНБ нийт 1.53 га талбайд хүлэмжид 9 төрлийн хүнсний нарийн ногооны тариалалт хийж, 20.7 тн ургац авсан. Хэрэгжилт 100%
		59	Ургац хураах тоног төхөөрөмжүүдийн хүртээмжийг шинэчлэх.(МАН мөрийн хөтөлбөр-5.1.2)	350.0	Ургац хураалтын тоног төхөөрөмж хүрэлцэхгүй байна.	Байцай тариалах, хураах тоног төхөөрөмжийг олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрт суулгах	Шинэ хөдөө төслийн хүрээнд байцаа хураан авах комбайн, ургамлын сийрүүлэгч, төмсний комбайн, дамарт усалгааны систем, 130 морины хүчин чадалтай трактор, хадлангийн диск хадуур, наран тармуур, үр тариа, ногоон тэжээл тариалах үрлэгч нийт 8 тоног төхөөрөмж аймгийн ХХААГазраас хүлээн авсан. Хэрэгжилт 100%

### 2.3. МАЛ АЖ АХУЙ

"2.3 Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн,	60	Шинэ хоршоо хөтөлбөр хэрэгжүүлэх. /ЗДҮАХ-3.8.7/ /ЗГ-ын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг өрнүүлэх тухай 166 дугаар тогтоол,	Банк, санхүүгийн зээлийн эх үүсвэр	Малын хадлан тэжээлийн газар нэмэгдүүлэх шаардлагатай, тэжээлийн ургамал Хадлан тэжээл, дарш, малын гаралтай түүхий эдийг бэлтгэж боловсруулах шаардлагатай.	"Мал аж ахуйн хоршоодыг тэжээллэг, малын гаралтай түүхий эд бэлтгэх ажлыг нэгдэж хоршиж хийхэд нь дэмжлэг үзүүлэх зээл, сургалт мэдээллээр хангана. “Олон Улсын Хоршооллын жил 2025”-ын хүрээнд хоршоодыг санхүү, хөрөнгө	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд нийт 57 хоршоо байгуулагдсан бөгөөд 2025 онд мал аж ахуйн чиглэлээр 6 хоршоо шинээр байгуулагдсан. Арилжааны банкны мал аж ахуйн хоршоодыг тэжээллэг, малын гаралтай түүхий эд бэлтгэх ажлыг нэгдэж хоршиж хийхэд нь дэмжлэг үзүүлэх зээлийн сангаас
--	----	--	------------------------------------	--	---	---

14	хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ. /Алсын хараа 2050-8.3/"		" УИХ-ын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар/"			оруулалт, үйл ажиллагаа явуулах байр, газар олгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх"	16 хоршоонд 1260.0 сая төгрөгийн зээл олголоо. Малчдад "Ногоон тэжээл тариалах, ач холбогдлыг таниулах" сургалтад хоршооны гишүүн 8 малчин хамрагдлаа. Малчны 4 хоршоо 30 га газарт ногоон тэжээл тариалсан. Хэрэгжилт 100%
		61	Мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжин ажиллаж, Мах, сүүний чиглэлийн Монбельярд үүлдрийн бухтай болно.	20.0	Мах, сүүний чиглэлийн Монбельярд үүлдрийн цэвэр эрлийз бух сумын хэмжээнд 6 толгой байна. Мах сүүний өндөр ашиг шимт бухтай болох сонирхолтой малчид олон байна.	Суманд үхрийг ашиг шимээр төрөлжүүлэн өсгөх үүлдрийн төрлийг тогтоож, малчдыг мэдээллээр хангаж 100 залуу малчныг туршлага судлах, сургалтад хамруулна.	Сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр тогтоолоор өндөр ашиг шимт үхэр сүргийг үүлдэр угсааг төрөлжүүлэн герефорд, симентал үхэр голчлон үржүүлэхээр шийдвэрлэлээ. Үхэр сүргийн хээлтэгч, хээлтүүлэгчийн тоог нэмэгдүүлэхээр малын тоо толгойн албан татварын орлогийн хөрөнгөнөөс 10.0 сая төгрөгөөр симентал үүлдрийн 4 толгой өсвөр хээлтүүлэгч авлаа. Олон улсын байгууллага, аймгаас зохион байгуулсан 6 удаагийн сургалт зөвлөгөөнд 46 малчин, мал бүхий иргэн, сумын "Малчны зөвлөгөөн 2025" арга хэмжээнд 120 малчин, мал бүхий иргэн тус тус оролцлоо. БНХАУ-ын ӨЗОронд хөдөө аж ахуйн дэвшилтэт технологи, фермэрийн аж ахуй, сүү цагаан идээ боловсруулах үйлдвэрлэл чиглэлээр 8 малчин, мал бүхий иргэнийг туршлага судлах аялалд 10.0 сая төгрөг зарцууллаа. Хэрэгжилт 100%
		62	Бог малын үржлийн ажлыг зорилго чиглэлтэй явуулж махны ашиг шимийг нэмэгдүүлэх.	-	Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид бог малын хээлтэгч төвлөрүүлдэггүй. 2024 онд 84 бог малын хээлтүүлэгчийг 1 малчин өрхөд ялган төвлөрүүлсэн.	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжид бог малын 138 хээлтүүлэгчийг бүрэн хариуцуулж гэрээ байгуулна. Зохиомол хээлтүүлгийн ажлын үр дүн 50 толгой төл хүлээж авна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 малчин өрхийн 36 толгой үнээнд, 4 малчин өрхийн 500 толгой эм хонинд зохиомол хээлтүүлэг хийгдсэнээс 22 толгой тугал, 84 толгой хурга хүлээн авч одоогоор зүй бусын хоргодолгүй бойжиж байна. Хэрэгжилт 100%

		63	Сумын аюулгүй нөөц бүрдүүлэх.	25.0	2024 оны сумын аюулгүйн нөөцөд 40 тн өвс, 6 тн тэжээл бэлтгэсэн.	Сумын аюулгүйн нөөцөд өвс 40 тн, тэжээл 25 тн бэлтгэнэ	2024 оны аюулгүйн нөөц 40 тн өвс, 6 тн хивэг бэлтгэсэн бөгөөд хаваржилт хүндрээгүй тул зарцуулаагүй нөөцлөгдөж байна. 2025-2026 оны өвөлжилтөд 10 тн өвс, 11 тн тэжээл, 100 кг эрдэс нэмэж бэлтгэлээ. Сумын аюулгүйн нөөцөд нийт 50 тн өвс, 17 тн тэжээл, 100 кг эрдэс байна. Хэрэгжилт 100%
		64	Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах.	Орон нутгийн төсөв, нэгжийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр.	2024 онд 84 бог малын хээлтүүлэгчийг 1 малчин өрхөд төвлөрүүлсэн.	Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад шилжүүлж гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хангуулна.	Энхтал багийн Ноёнхонгор хэсгийн 1 малчин өрхөд 69 бог малын хээлтүүлэгчийг хариуцуулж, хээлтүүлгийн бус үед маллуулж байна. Хэрэгжилт 100%
		65	Мал аж ахуйн салбарт тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах, мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮА-3.3.4, АЗДҮАХ-3.3.4.18.1/	38.0	Сумын хэмжээнд 11 төрлийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 116.0 мянган толгой мал, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 3 арга хэмжээнд 86.7 толгой мал хамруулсан.	11 төрлийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 86 мянган толгой мал, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 3 арга хэмжээнд 78 мянган толгой мал хамруулах	Сумын Засаг даргын 2025 оны 01-А/47, 01-А/54, 01-А/224 дугаар захирамжийн дагуу 12 төрлийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 111.2 мянган толгой мал, амьтан хамрагдлаа. Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/26 дугаар тушаалын дагуу сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дугаар тогтоолоор "Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө" –ний дагуу 3 арга хэмжээнд давхардсан тоогоор 83.3 толгой мал хамруулсан. Хэрэгжилт 100%
		66	Мал амьтны өвчнийг тандах шинжилгээг жил бүр зохион байгуулах үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах /ЗГҮА-3.3.4, АЗДҮА3.3.4.17.2	2.0	2024 онд шүлхий, бог малыг мялзан, үхрийн сүрьеэ, лейкоз, бруцеллэз, адууны 4 өвчний тандалт шинжилгээ хийгдсэн. Бруцеллэз өвчний халдварлалт 0.4 хувь, үхрийн сүрьеэ, лейкозын үүсгэгч илрээгүй.	Тандалт шинжилгээнд 1.4 мянган толгой мал хамруулна. Бруцеллэзын халдварын түвшин 0.02 хувиар буурсан байна.	Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын тушаалын дагуу "Бруцеллэзын хээлтүүлэгчийн тандалт шинжилгээ 2025" тандалтын арга хэмжээнд дээж цуглуулах ажлын гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор сумын 156 бух 94 хуц, 116 ухна нийт 366 эцэг малаас цусны дээж авсан бөгөөд мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний дүнгээр бүгд сөрөг дүнтэй гарсан. Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/233 дугаар тушаалын дагуу "Бруцеллэз өвчний халдвар илрүүлэх хээлтүүлэгчийн тандалт шинжилгээний ажлыг зохион байгуулах шийдвэрийн дагуу сумын хэмжээнд 500 саалийн үнээнээс цусны шинжилгээнд хамруулж, шинжилгээний д

							үнгээр 2 өрхийн 14 үнээнээс бруцеллээ халдвар илэрч 14 үнээг шаардлагаар хэрэгцээлүүлсэн. Бруцеллэзын халдварын түвшинг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 51.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 100%
<b>3.1. ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО</b>							
15	"3.1 Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай бүтэц тогтсон байна. /Алсын хараа 2050-5.2.1/"	67	Орхон сумын хот байгуулалтын хөгжлийн төлөвлөгөө боловсруулна. /АЗДҮАХ-1.4.1/	146.6	Орхон сумын урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө боловсруулаагүй байна.	Сумын хот байгуулалтын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна	Сумын хот байгуулалтын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах 126.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг "Гоби травелл" ХХК гүйцэтгэлээ. Төлөвлөгөөг сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулах хүсэлт ирүүлсэн. Хэрэгжилт 100%
		68	Төрийн байгууллагын ажилчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах	20.0	Хүний нөөцийн тогтворжилт муу, төрийн албан хаагчдын амьдрах нөхцөл дунд	5 төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн асуудлыг шийдвэрлэх	Сумын Засаг даргын 2025 оны 01/-А205 дугаар захирамжаар батлагдсан төрийн албан хаагчдын 2 ба түүнээс дээш давхар орон сууцны газрыг шийдвэрлэлээ. Төрийн өмчийн 4 орон сууцыг сургууль, цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ-ын 8 албан хаагчид хувиарлан орон сууцаар хангалаа. Сумын ЗДТГ-т 2025 оны эхний 11 сарын байдлаар өссөн дүнгээр цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 952.9 сая төгрөг батлагдсанаас 30 албан хаагчид 858.1 сая төгрөгийн цалин урамшуулал, тэтгэмж олголоо. Үүнд: 1.Цалин 30 албан хаагчид 858.1 сая, 2. Орон нутгийн нэмэгдэл 209.4 3.Унаа, хоолны хөнгөлөлтөнд 27 албан хаагчид 15.2 сая 4. Үр дүнгийн урамшуулалд 24 албан хаагчид 61.2 сая, 5. Илүү цаг 24 албан хаагчид 15.5 сая, 6. Ажил олгогчоос 24 албан хаагчид түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт 8.4 сая 7. Гачигдал тохиолдсон 7 албан хаагчид 12.8 сая, 8. Дотоод албан томилолт 8 албан хаагчид 6.6 сая төгрөгийг тус тус олгосон Хэрэгжилт 100%

		69	Төрийн үйлчилгээг цахимжуулах	5.0	Төрийн үйлчилгээний цахимжуулалт хангалтгүй байна.	Төрийн үйлчилгээний цахимжуулалтыг 40%-д хүргэх.	Сумын ЗДТГ-ын вэб хуудас шинэчлэгдэж, иргэд тус сайтаар төрийн мэдээ мэдээлэл авах, малчны А дансны лавлагаа, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн материалаа цахимаар илгээх, мөн байгууллагын дотоод архивын үйл ажиллагааг "Архивын програм"-аар хөтлөн ажиллуулахаар 1.8 сая төгрөг зарцуулаа. Аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран албан бичиг, өргөдөл гомдол, санал, хүсэлт хүлээж авах, хариу өгөх үйлчилгээг үнэгүй цахимжуулах, сумын хог, хаягдал, ус, дулааны төлбөр тооцоог төлбөр тооцооны нэгдсэн системд холбох, хогийн пункерүүдэд сисо бүтээгдэхүүн байрлуулахаар шийдвэрлэлээ. Багийн Засаг даргын тодорхойлолтыг E-MOYGOLIA-д оруулах хүсэлт дээд шатны байгууллагад хүргэлээ.  Хэрэгжилт 100%
		70	"Орхон Брэнд" бичил кластерын загвар баталж, хэрэгжүүлэх. /Алсын хараа 2050-4.5.2, АХ2050 2021-2030 хэрэгжүүлэх төлөвлөгөө-3.3.1/ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5.11 дэх заалт"	10.0	Өрхийн аж ахуй, бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх Кластерын загвар байхгүй.	Засаг даргын дэргэдэх зөвлөл байгуулж, үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, зөвлөх үйлчилгээ авч бэлтгэл ажил хангах;	Сумын онцлогт тохирсон бүтээгдэхүүн гаргах, сурталчлан таниулах, борлуулалтын сувгийн нэмэгдүүлэх зорилгоор улс, аймагт зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаанд тус сумын үйлдвэрлэл эрхлэгч 8 аж ахуйн нэгж байгууллага, 17 өрхийн үйлдвэрлэгч нар 10 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 1 аж ахуйн нэгж улсын үзэсгэлэн худалдааны Шилдэг үйлдвэрлэгчээр шалгарлаа. Сумын хэмжээнд зохион байгуулагдсан сумын "Брэнд бүтээгдэхүүн" шалгаруулах удирдамжын хүрээнд цагаан идээ, даршилсан бүтээгдэхүүн, гар урлал, хоол үйлдвэрлэл, хүнсний ногоо зэрэг төрлүүдээр 12 иргэн, хоршооны төлөөлөл оролцож, цагаан идээгээр боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1, даршилсан бүтээгдэхүүнээр 1 хоршоо, цагаан идээ, гар урлал, дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр 1 хоршоог шалгаруулж Өргөмжлөл олголоо.  Хэрэгжилт 100 %
<b>3.2. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО</b>							

16	"Зорилт 3.2 Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн түвшнийг бүрэн тодорхойлно. /Алсын хараа 2050-7.3.3/"	71	"Гамшгийн үеийн бэлэн байдал, иргэний хамгаалалт, мэргэжлийн ангийн харилцаа холбооны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэн, мэргэжлийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулна. /ЗГҮАХ-4.4.4.3, 4.4.4.15)"	33.0	"Мэдээллийг иргэдэд цаг алдалгүй хүргэх багц үйлчилгээ байхгүй. 1974 онд анх ажиглалтын талбай барьсан. Ашиглалтын хугацаа дууссан."	"СӨБ, ЕБСургуульд гамшгийн эрсдэлийг бууруулах хүүхдийн сургалт, дадлагын булан байгуулах. /ЗДҮАХ-4.9.1.1/ Цаг уурын ажиглалтын 20м*20м нийт 80м урт талбайн хашаа хийх, цаг уурын багаж байрлуулах зориулалтын бүхээг хийх /ЗГҮАХ 3.4.2.6/ Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн сургалт, дадлагыг зохион байгуулах, шаардлагатай материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх /ЗДҮАХ 4.5.1 Сумын нөөц цахилгаан үүсгүүрт онцгой объектуудын төвлөрсөн цахилгаан шугамыг холбох ажил хийгдэнэ."	Сумын Засаг даргын хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 9.9 сая төгрөгөөр ЕБСургууль, 9-р цэцэрлэгт 12 нэр төрлийн 17 ширхэг багаж, хувцас хэрэгсэлтэй гамшгийн эрсдлийг бууруулах сургалт, дадлагын булан байгуулж, хүлээлгэн өглөө Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сумын цаг уурын Шарын гол харуулын ажиглалтын талбайн хашаа шинэчлэх, цаг уурын багаж байрлуулах бүхээг шинээр хийх ажлыг 5.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан томилгоот нэгжийн сургалтад 1, 2-р ээлжийн 2 бүлгийн 22 албан хаагчийг хээрийн дадлага сургалтад хамрууллаа. Томилгоот нэгжийн алба хаагчдыг 3.6 сая төгрөгийн үнэ бүхий 30 хувцас хэрэгслээр хангалаа. Сумын галын сарайг ЗДТГ-ын авто гражийн хажууд нүүлгэхээр 2025 оны төлөвлөгөөнд тусгаж байгууллагын дотоод нөөц бололцоогоор засварын ажлыг хийж тохижуулахад 1.2 сая төгрөг зарцууллаа. Сумын нөөц цахилгааны үүсгүүрийг ДСЦТШС-тэй хамтран цахилгааны шугамд холбож бэлтгэсэн. Хэрэгжилт 100 %
		72	Цас цэвэрлэгээний тоног төхөөрөмжтэй болох	20.0	Цас цэвэрлэгээний тоног төхөөрөмжгүй	Цас цэвэрлэх тоног төхөөрөмжтэй болох	"Динамик тек" ХХК-тай гэрээ байгуулан цас шүүрдэх, бутлах, түрэх зориулалттай тоног төхөөрөмж 5.9 сая төгрөгөөр худалдан авч ашиглаж эхэллээ. Сумын Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас ковшид суурилуулах зориулалттай цасны хутга 1 , хүнд даацын гидр цас цэвэрлэх шүүр худалдан авахад 30.4 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэлээ. Хэрэгжилт 100%
<b>3.3. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО.</b>							

17	"3.3 Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе. /Алсын хараа 2050-5.5/"	73	"Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ./ЗДҮ АХ-2.2.1.4/	5.0	Шинээр батлагдаж буй хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэдийн эрх зүйн боловсролыг тасралтгүй нэмэгдүүлэх шаардлагатай	Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх.	Сумын ЗДТГ-аас жилийн эцсийн байдлаар 7 төрлийн хуулийн 7 чиглэлээр 150 иргэнд хууль зүйн мэдээлэл, зөвлөгөөг өгч, 3 эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж 365 иргэн оролцлоо. www.orkhon.da.gov.mn вэб сайтад 6 төрлийн 20 , мэдээллийн самбарт 5 төрлийн 30 мэдээлэл, "Орхон сумын Засаг даргын Тамгын газар" фейсбүүк хуудас болон группт 48 төрлийн 120 удаагийн мэдээлэл, сурталчилгаа байршуулснаас давхардсан тоогоор 38.0 мянган иргэн хандаж мэдээлэл авсан. Хэрэгжилт 100%
		74	Сумын иргэдийн "Хүний эрхийг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх /ЗДҮАХ-4.1.1	5.0	Суманд гарч буй хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр байхгүй.	Хүний эрхэд суурилсан хандлага, сэтгэлгээг төлөвшүүлэх.	Хүний эрхийг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд 15 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 100 хувьтай байна. Үүнд: Аймгийн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран "Хүний эрхэд суурилсан хандлага, сэтгэлгээ" сургалтад 23 иргэн, 22 төрийн албан хаагч хамрагдлаа. "Манлайлал ба харилцааны ур чадвар"-ын сургалтад 35 албан хаагч хамрагдлаа. Тайлант онд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр "Хамтарсан баг" 23 кейс илрүүлж 52 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүллээ. Хэрэгжилт 100%
		75	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Аюулгүй ногоон бүс" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	5.0	Суманд гарч болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинээр хорооллуудад цамхагт гэрэлтүүлэг, камержуулалтыг 19 цэгт байршуулсан.	Суманд хийгдсэн камержуулалтын хяналтыг нэг цэгт нэгтгэн нэгдсэн хяналтын цэгтэй болох	Сумын хэмжээнд 27 камерын хяналтыг цагдаагийн хэсэгт нэгтгэсэн бөгөөд үүнээс 19 камерийг аймгийн камерийн нэгдсэн төвд холбосон. Хэрэгжилт 100%
<b>ДЭРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
<b>4.1. НОГООН ХӨГЖИЛ</b>							

18	Зорилт 4. Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. (Алсын хараа-2050-6.1, ЗГҮАХ хөтөлбөр-3.4.1.6)	76	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 40 га газрыг ойжуулах. ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлэх/ЗГ ҮАХ-3.4.1.4, ДҮАХ-3.10.3/	-	Тус суманд 2024 онд 2 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг эхлүүлсэн.	Сумын 60 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд Төрийн болон ААНБ-ын ногоон байгууламжийн талбайг чимэглэлийн мод тариалах, албан байгууллагаас цэцэрлэгжүүлэлтийн сургалтад хамруулах. сумын төвийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх. Наадмын талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан 1 тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тус суманд 2025 онд давхардсан тоогоор 16 ААНБ, 62 айл өрх 17905 мод тариалсан. Үүнээс: - Сумын ОНХ-ын сангаас 2025 онд 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Наадмын талбай”-д ногоон байгууламжийн хашаа, 10.0 сая төгрөгөөр 90 ширхэг нарс, 300 ширхэг агч мод Биж бугат ХХК шалгарч тариаллаа. - Намрын бүх нийтийн мод тарих өдрөөр төрийн албан хаагчид, сургуулийн сурагчид болон 1995 оны 86 ангийн төгсөгчид иргэн Д.Дамдинжамц, Н.Гандулам нарын хандивласан 620 ширхэг агч мод нэмэж тариалсан. Аймгийн байгаль хамгаалах сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ойн хортонтой тэмцэх ажлыг 500 га талбайд биобэлдмэлээр Хоймор форест ХХК гүйцэтгэсэн. Хэрэгжилт 100%
		77	Хог хаягдлыг цогц менежментийг хэрэгжүүлж иргэн бүрийг хогоо ангилж хаях соёлд суралцахыг уриалж хогийн цэгийг	10.0	Суманд хэмжээнд 2 цэгт төвлөрсөн хогийн цэгийг ажиллуулж байна. Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ жилд 1488 тн орчим хогийг ачиж	Сумын хэмжээнд ААНБ, айл өрхөөс гарч байгаа хог хаягдлын эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах, нийт 300 орчим өрх, иргэнд сургалт сурталчилгаа хийх. Төвлөрсөн хогийн цэгийг ландшафиллийн	2025-2028 онуудад нүхэн жорлонг бууруулах судалгаа, аймгийн хэмжээнд мөрдөх “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах” журамд тусгах сумын саналыг боловсруулж хүргүүлээ. Сумын хэмжээнд 468 өрхийн 2200 м.куб хог хаягдлыг татан зайлуулж, төвлөрсөн 2 хогийн цэгийг 6 удаа ландшафилл аргаар цэвэрлэсэн. Сумын Засаг даргын 2025 оны 01-А/30 захирамжаар бүх нийтийн их цэвэрлэгээг Баян-Өлзийт, Энхтал багт тус бүр 1 удаа зохион байгуулж 80 орчим тн хог хаягдал төвлөрсөн цэгт хүргэсэн.
			тарималжуулах шинэ технологи нэвтрүүлнэ. (ЗДҮАХ-3.11.3)		тээвэрлэсэн. 2024 онд Энхтал багийн Бүрэнтолгой, 96-р зөрлөгт айл өрхийн хог хаягдлыг хуваарийн дагуу ачиж эхлээд байна.	аргаар булшлах арга хэмжээг жилд 1-с доошгүй удаа зохион байгуулна.	Эмнэлгийн аюултай хог хаягдлыг “Элемент медиал ХХК-тай гэрээ байгуулан халдвартай хог хаягдал 319.5 кг, хурц үзүүртэй хог хаягдал 206.5 кг-ыг устгууллаа. Хог хаягдлыг ангилан ялгах, орчны бохирдлоос сэргийлэх чиглэлээр иргэдэн, ААНБ-д зориулсан зөвлөмж Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ цахимаар 2 удаа, ЗДТГ-аас 4, багуудаас 2, нийт 8 төрлийн зөвлөмж 7 удаагийн давтамжтайгаар цахимаар иргэдэд хүргэсэн бөгөөд нийт 264 иргэн үзсэн байна. Хэрэгжилт 100%

		78	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, менежментийг сайжруулах,	4.0	"-Ойн хөнөөлт шавжийн тархалт тэмцэх ажлыг 2021 онд 1300 га талбайд хийсэн. -Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлын тогтмол зохион байгуулж 3 удаагийн хяналт шалгалт явуулж жилд 2.0 сая төгрөг зарцуулдаг"	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр жил бүр 3-с доошгүй удаагийн эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, сумын нийт нутаг дэвсгэрт 5 морин эргүүл ажиллуулах	Аймгийн ОБГ, сум дундын ой анги, БОГ-аас "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын бэлтгэл бэлэн байдлыг 2 удаа хяналт шалгалт хийж зөвлөмж өгсөн. Сумын ЗДТГ-аас ой хээрийн түймрээс сэргийлэх 3 удаагийн хяналт шалгалт, эргүүл зохион байгуулж 125 айл өрхөд сэрэмжлүүлэг анхааруулга өглөө. Сумын хэмжээнд 5 чиглэлд морин эргүүл ажилласан. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан ойн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх арга ажиллагаа, авах арга хэмжээ сэдэт сургалтад 3 нөхөрлөл, 4 идэвхитэн байгаль хамгаалагч нар хамрагдлаа. Сумын ЗД-ын 2025 оны 01-А/39 дугаар захирамжаар ой хээрийн түймрийг хариуцлагатай жижүүрийн хуваарийг батлан хэрэгжүүллээ.  Хэрэгжилт 100%
		79	Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулж бодлогоор дэмжинэ.	ААНБ-ын зардлар	Уул уурхай олборлох чиглэлээр 2024 онд 3 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг ААНБ-ын хөрөнгөөр гэрээ байгуулах замаар гүйцэтгүүлж хүлээн авсан.	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААНБ-тай дүйцүүлэн хамгаалах болон нөхөн сэргээлтийн гэрээ байгуулах замаар эвдэрсэн 0.5 га-аас багагүй талбайг жил бүр ААН-ын зардлаар нөхөн сэргээлт хийлгэнэ.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд 3 удаа хяналт шалгалт хийж ОНО-д 23.0 сая төгрөгийн АМНАТ төвлөрүүлэхээс 43.1 сая төвлөрүүллээ. Тайлант онд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч Сонголон хайрхан ХХК, Анто-Од ХХК, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Түшиг-Уул ХХК-тай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллалаа.  Хэрэгжилт 100%
		80	Байгаль орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж ажиллах	1.0	Сумын хэмжээнд 2024 оны байдлаар усан халаалтын зуух 6 ширхэг, айл өрхийн зуух 700 орчим зуух	Хүлэмжийн хийн ялгарал, агаарын бохирдлыг бууруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, ААНБ, иргэдийн санаачлагыг дэмжинэ. Агаарын бохирдуулагч эх үүсвэрийн тоог бууруулж	Сумын хэмжээнд 2025 оны байдлаар усан халаалтын зуух 6 ширхэг, айл өрхийн зуух 700 орчим зуух галлаж жилд 4000 тн орчим түүхий нүүрсийг хэрэглэж байна. 2025 оны тооллогоор 695 айл өрх тоологдож 5 яндан буусан байна

					галлаж жилд 4000 тн орчим түүхий нүүрсийг хэрэглэж байна.	ГБХНХЯ, Найрамдал төслөөс хэрэгжүүлж байгаа "ЧИП" төслийн сургалтыг орон нутагт зохион байгуулна. Галлагаатай өрхийн тоог 2 хувь багасгана	. Байшингаа дулаалсан айл өрхийн тоо энэ онд 10 байна. Галлагаатай өрхийн тоог өнгөрсөн онтой харьцуулахад 17 буюу 2.39 хувь буурлаа Аймгийн БОГазар, Монгол гэрт зориулсан эрчим хүчний хэмнэлттэй "Дулаалга, халаалт, агаар сэтгэлтийн ЧИП багц"-ын талаар мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулж 9 албан хаагч оролцлоо. Хэрэгжилт 100%
		81	Уул уурхайн олборлолт, АМНАТ-ын төлөлтийн байдалд хяналт тавих, ОНОрлогыг нэмэгдүүлэх	1.0	2024 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 25 сая төгрөгийн төлөвлөгөөтэйг өөс 43.9 сая төгрөг ОНО-д төвлөрүүлсэн.	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААНБ-уудын олборлолтын үйл ажиллагаанд орон нутгийн зүгээс тавих хяналтыг сайжруулж, орон нутгийн төсвийн орлогод 25.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 ААН, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1 ААН-ын үйл ажиллагаанд 3 удаа хяналт шалгалт хийж ОНО-д 23.0 сая төгрөгийн АМНАТ төвлөрүүлэхээс 43.1 сая төвлөрүүлээ. Хэрэгжилт 100%
		82	Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх	0.5	2024 онд байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нийт 12 удаагийн хяналт шалгалт явуулж зөрчлийн шинж чанартай 7 гомдол мэдээллийг шалган шийдвэрлэсэн.	Хууль бус ан агнууртай тэмцэх, түүнийг таслан зогсоох чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг улиралд 2-с доошгүй удаа явуулж гэмт хэргийн илрүүлэлтийг тоог нэмэгдүүлэх. 2-с доошгүй удаагийн гомдол мэдээллийг шалгаж хэргийг шийдвэрлэх	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг нийт 15 удаа явуулж БОНБУ-ний тухай хууль зөрчсөн 5 ААН, ойн тухай хууль зөрчсөн 3, амьтны тухай хууль зөрчсөн 4, усны тухай хууль зөрчсөн 1 удаагийн зөрчлийг илрүүлж Зөрчлийн тухай хуулиар 5 ААН, 6 иргэнд хариуцлага тооцож зөрчлийг арилгуулж, 12.36 сая төгрөгийн хохирол барагдууллаа. Хэрэгжилт 100%
<b>4.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b>							
19	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААНБ-тай дүйцүүлэн хамгаалах болон нөхөн сэргээлтийн гэрээ байгуулах замаар эвдэрсэн 0.5 га газрыг жил бүр ААН-ын зардлаар нөхөн сэргээлт хийлгэнэ.	83	Сумын онцлогт тохирсон дотоодын болон гадаад аялал жуулчлалыг хөгжүүлэх	10.0	Төлөвлөгөө боловсруулагдаагүй.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх сумын төлөвлөгөө боловсруулах	Тус сумын нутагт Их булангийн хөндийд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг эвент арга хэмжээ болох мөсний загасчлалын "Дархан цом-2025" тэмцээн болж, тус тэмцээнд 25 багийн 100 гаруй тамирчин, зохион байгуулах комисс, шүүгчдийн баг, дасгалжуулагчдын бүрэлдэхүүний хамт нийтдээ 150 гаруй хүн оролцсон өргөн бүрэлдэхүүнтэй тэмцээн боллоо. Хэрэгжилт 100%

19 зорилт 83 арга хэмжээ 80 зорилтот түвшин

Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2025 онд 19 зорилт 83 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт **99.2** хувьтай хангаж ажиллалаа.

Үүнд Тухайн жилд:

Биелэлт: 100 хувьтай 82 арга хэмжээ

30 хувьтай 1 арга хэмжээ

**ТАНИЛЦСАН:**

**ЗАСАГ ДАРГА**

**Б.ТҮМЭНЦОГТ**

**ХЯНАСАН:**

**ЗДТГ-ЫН ДАРГА**

**С.ДЭЛГЭРЖАРГАЛ**

**ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:**

**ХНХШҮХАЖИЛТАН**

**А.БОЛОРЧИМЭГ**